



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 07 дугаар сарын 29 өдөр Дугаар 69

Хэрлэн сум

LXIX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 69 дүгээр хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 15:00 цагт Засаг даргын тамгийн газрын хурлын танхимд 81,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Монголын морин спорт уяачдын холбооноос ирүүлсэн албан хүсэлтийг хэлэлцэж, холбогдох шийдвэр гаргах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

2. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлт танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

- Аймгийн Музейгээс ирүүлсэн хүсэлт,
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс ирүүлсэн хүсэлт,
- Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлт,
- Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн хүсэлтийг тус тус танилцуулах.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголын морин спорт, уяачдын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд хурдан морины уралдааныг азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага гэсэн 6 наснаас гадна эрлийз /сонгомол/ морины уралдааныг бага, дунд, дээд гэсэн 3 насны ангиллаар 2021 оны 8 дугаар сарын 6, 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулахаар хамтарсан комисс гаргаж зохион байгуулах тухай саналыг аймгийн Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцэн 100 хувийн саналаар дэмжив.

Шаардлагатай дэмжлэг үзүүлэх агентлаг, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд хамтран ажиллах,

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Хурдан морины уралдаан зохион байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

 / М.Бадамсүрэн  
/ Хүр Г.Нармандах

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах  
Мэргэжлийн хяналтын газрын дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Хөлөнбуйр сумын Засаг дарга, Онцгой комиссын  
дарга У.Ганхуяг нарт:

1.2.Хөлөнбуйр сумын хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд хяналт тавих, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллах,

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Баяржаргал-д:

1.3.Хурдан морины уралдаан зохион байгуулах өдрүүдэд Хөлөнбуйр, Булган сумдад согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулж танилцуулах,

Хоёр.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын дарга,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн А.Нансалмаа нарт:

2.1.Бүх шатны сургалтын төв, саун, бассейн, нийтийн халуун усны газруудыг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх,



Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

3.1.Хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэлд 30-аас ихгүй хүнтэйгээр Чойбалсан-Улаанбаатар, Улаанбаатар-Чойбалсан чиглэлд 7 хоногийн өдөр бүр нэг удаа дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан иргэнийг зорчуулах, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах,

Дөрөв. Ачаа, тээврийн үйл ажиллагаанд хяналт  
тавих ажлын хэсгийн ахлагч нарт:

4.1.Цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийг хэлэлцэн Замын цагдаагийн тасгаас тавьж буй шаардлагын дагуу Замын хөдөлгөөний дүрмийн 2.11 хэсэгт зааснаар 15 тн-оос дээш жинтэй хүнд даацын тээврийн хэрэгслүүдийг Чойбалсан хотын төв замаар зорчуулахгүй, гэр хорооллын сайжруулсан шороон замаар нэвтрүүлж, босоо чиглэлд хөдөлгөөн үйлдүүлэн ажиллах,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

/  / М.Бадамсүрэн  
/  / Хур Г.Нармандах

5.1.Уул уурхайн компаниудад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллах,

5.2.Уул уурхайн компаниудын тусгаарлан ажиглах байрны өрөө тус бүрт ариун цэврийн өрөөтэй байлгахаар 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бэлэн байдлыг хангуулах талаар албан бичгээр чиглэл хүргүүлэх,

5.3.Төрийн алба хаагчид албан томилолтоор ажиллах үедээ коронавируст халдварын батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болсон албан хаагчийг 7 хоног гэрийн тусгаарлалтад шилжүүлэх талаар төрийн байгууллагуудад чиглэл өгөх,

Зургаа.Музейн захирлын үүргийг түр орлон  
гүйцэтгэгч В.Нарангэрэл-д:

6.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тус объектын агаар сэлгэлт шаардлага хангагдаагүй тул Музейн үйл ажиллагааг нээхийг түр хугацаагаар хойшлуулах,

Долоо.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

7.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр иргэд, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн бараа, материалын дэмжлэгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, зарцуулах эрхийг дээд шатны байгууллага болох Эрүүл мэндийн яаманд хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх.

ДАРГА



М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА,  
ХУРАНДАА

Г.НАРМАНДАХ

/

/ М.Бадамсүрэн

/

/ Хур Г.Нармандах